

## СУДАЛГАА

АНАГААХЫН ОЮУТНУУДЫН АНГЛИ ХЭЛНИЙ ГЭРИЙН ДААЛГАВАР  
ХИЙХ ӨДӨР, СУРЛАГЫН АМЖИЛТЫН ХАМААРАЛ

Б. Мөнхзаяа<sup>1</sup>, Г.Мөнхцэцэг<sup>1</sup>

АШУУИС, БиоАС-ийн Гадаад хэлний тэнхим

munkhzaya.b@mnums.edu.mn

**Түлхүүр үгс:** Анагаахын оюутан, англи хэл, гэрийн даалгавар, цагийн зохицуулалт

**Судалгааны ажлын үндэслэл:** Анагаахын оюутнуудад англи хэлний чадвар нь дэлхийн түвшний мэдлэгтэй болоход, мөн мэргэжлийн салбартаа амжилтгаргахад зайлшгүй шаардлагатай. Англи хэлний мэдлэгтэй болоход бие даан сурах арга барилд сургах нь англи хэлний хичээлийн нэг чухал зорилт юм. Бие даан суралцаж сурахад нөлөөлдөг хамгийн анхны шат бол гэрийн даалгавар. Гэрийн даалгавар нь багшийн шууд удирдлагагүйгээр тухайн сурагч өөрөө багшийн зааж зөвлөсний дагуу биеэ даан бодож боловсруулан хийж гүйцэтгэдэг хичээлийн өвөрмөц онцлог шинж бүхий үндсэн хэлбэр (Ц.Мягмарсанж, 1983), зарим үед хичээлийн үргэлжлэл болдог (М.Оюунчимэг, 2015) тухай гэрийн даалгаврын ач тусыг олон судалгаагаар баталж харуулжээ.

Цагийн менежмент, өөрийгөө удирдах чадвар нь гэрийн даалгавар гүйцэтгэхэд чухал ач холбогдолтой (Ху, 2010), цаг тухайд нь хийснээр сургалтын амжилтад нөлөөлдөг (Cosio нар), мөн өөрийгөө хянаж удирдах арга барил нь анхаарлаа төвлөрүүлэхэд чухал үүрэгтэй (Yang & Tu, 2020) болох гэх мэтчилэн олон талаас нь эрдэмтэн судлаачид судалсан байна.

Түүнчлэн Ху нар (2014) нь гэр бүлээсээ дэмжлэг авдаг, цагийг зөв зохицуулдаг оюутнууд илүү амжилттай суралцдаг болохыг тэмдэглэсэн байна. Химийн оюутнуудын хувьд хичээл орохоос өмнө гэрийн даалгавраа хийснээр шалгалтын ононд эерэгээр нөлөөлдөг болохыг Косио нарын судлаачид тогтоожээ.

Харин гэрийн далгаавар хийж гүйцэтгэхэд тохиромжтой өдрийг тогтоох судалгаа ялангуяа анагаахын оюутнуудын хувьд хангалтгүй байна. Тиймээс бид энэхүү судалгаагаар гэрийн даалгаврыг гүйцэтгэх өдөр сурлагын амжилтад хэрхэн нөлөөлж байгааг судлахыг зорилоо.

**Зорилго:** Анагаахын оюутнуудын англи хэлний гэрийн даалгавраа хийдэг өдөр, сурлагын амжилтын харилцан хамаарлыг судлах

**Арга аргачлал:** 2023-24 оны хичээлийн жилийн 2 дугаар улиралд англи хэл судалсан 1 дүгээр курсын оюутнуудын дунд уг судалгааг явуулсан бөгөөд нийт 48 оюутан судалгаанд (70% эмэгтэй, 30% эрэгтэй) оролцсон. Судалгааг Гүүгл формыг ашиглан нээлттэй болон хаалттай асуулт онлайн асуулгаар явуулсан. Өгөгдлийг Excel, SPSS статистик программ ашиглан боловсруулсан.

**Үр дүн****1. Англи хэлний түвшин**

Судалгааны дүнгээс үзэхэд оюутнуудын 80 гаруй хувь нь анхан дунд болон дунд түвшний англи хэлтэй байна. Өөрөөр хэлбэл, англи хэл сурах чухал үешатандаа явж байгаа оюутнууд юм. Тиймээс эдгээр оюутнуудын хэлний түвшин сурах зан үйлд нь нөлөөлдөг байж болох талтай. Ахисан түвшний англи хэлтэй оюутнууд цагаа үр дүнтэй хуваарилах, сурах арга барилаа олсон байх зэрэг давуу талтай байдаг бол олонхи болсон дунд шатны оюутнуудад гэрийн даалгавраа үр дүнтэй хийх системтэй дэмжлэг хэрэгтэй байдаг.

**2. Өмнөх улирлын шалгалтуудын онооны дундаж**

Судалгаанд оролцогчдын 60 орчим хувь нь өмнөх улиралд шалгалтуудаа

дунджаар 80-аас дээш хувьтай өгч амжилттай сайн сурсан байна. Гэрийн даалгавраа хийх өдөр, шалгалтуудын онооны дунджийн хамаарал бага зэрэг сөрөг (Пиерсоны коэффициент: -0.267) гарсан бөгөөд гэрийн даалгавраа тулгаж хийдэг оюутнуудын дүн арай доогуур гарсан байна.

**3. Англи хэлний гэрийн даалгавар хийдэг өдөр**

Оюутнуудын нэлээд их хувь нь (54%) англи хэлний хичээл орохын өмнөх өдөр буюу цагийг нь тулгаж хийдэг бол багагүй хувь нь (40%) хичээл орсноос 2-3 хоногийн дараа гэрийн даалгавраа хийдэг байна. Эдгээр оюутнууд ойлголтоо бататгаж, шинэ мэдлэгээ өөрийн болгохыг хичээдэг. Мөн өөр өөр өдөр сонгож байгаа нь сурах янз бүрийн дадал зуршилтай болохыг илтгэж байдаг.

**4. Тухайн өдрийг сонгох шалтгаан**

Гэрийн даалгаврыг хойшлуулж хийдэг гол шалтгаан бол бусад хичээлийн даалгавраа хийх (42%) гэсэнтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл, анагаахын оюутнууд даалгаврын ачааллаа зохицуулахад бэрхшээлтэй байдгийг харуулж байна. Гэсэн хэдий ч гуравны нэг нь (33%) цагаа зөв зохицуулж

чадаж байгаа нь цагаа зохицуулах, өөрийгөө хянаж удирдах чадварыг эзэмшихийн ач холбогдлыг онцолсон судалгааны үр дүнг баталж байна. Цөөн оюутнууд (2%) гэрийн даалгавраа хийх өдрийн сонголтоо залхуурсантай холбоотой гэж үзжээ.

**Хэлэлцүүлэг**

- Гэрийн даалгавраа хийх болон сурлагын амжилтын хооронд бага зэрэг сөрөг хамаарал (-0.267) байгаа нь гэрийн даалгавраа тулгаж гүйцэтгэсэн оюутнуудын сурлагын амжилт бага зэрэг тааруу байх хандлагатайг харуулж байна.
- Оюутнуудын дийлэнх нь (54%) гэрийн даалгавраа хичээлийн өмнөх өдөр дуусгахыг илүүд үздэг байгаа нь цагаа зохицуулж сураагүй, эсвэл ингэснээр сурсан мэдлэгээ дараагийн хичээл дээр бататгахад дөхөмтэй байдаг бол 40% нь хичээл орсноос хойш 2-3 хоногийн дараа хийх нь тухайн даалгаврыг цаг зав гарган ойлгож хийхийг хичээдэг байна.
- Оюутнуудын нэлээд хэсэг (42%) бусад хичээлийн даалгаврыг хийгээд завгүй байдаг тул гэрийн даалгавраа хойшлуулдаг гэжээ. Үүнээс үзвэл, оюутнууд цагаа зохицуулах чадвараа сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.
- Цагаа үр дүнтэй хуваарилж чаддаг оюутнууд илүү өндөр оноо авах хандлагатай байдаг нь сурлагын амжилтад өөрийгөө удирдан чиглүүлэх чадвар чухал болохыг онцолж байна.

**Дүгнэлт**

1. Гэрийн даалгавар хийх өдөр сурлагын амжилтад бага зэрэг нөлөөлдөг бөгөөд эрт гүйцэтгэх нь илүү сайн үр дүнд хүргэдэг байна.
2. Олон оюутнууд сүүлийн хугацаанд тулгаж гэрийн даалгавар хийж байгаа нь гэрийн даалгаврын үр дүнг бууруулж, тухайн тмэдлэгийг өөрийн болгож чадахгүйгээс гадна сурлагын амжилтад сөргөөр нөлөөлөхөд хүргэж

байж болох юм.

3. Цагаа зохицуулж сурах нь ялангуяа анагаахын хичээлийн ачаалал ихтэй оюутнуудын хувьд маш чухал юм.
4. Багшийн зүгээс гэрийн даалгавар хийх арга барилыг сайтар тайлбарлаж өгөх, шалгах үйл ажиллагаагаа сайн зохион байгуулж өгснөөр оюутнуудын урам зоригийг дээшлүүлнэ гэж үзэж байна.

**Ёс зүйн зөвшөөрөл**

Судалгаанд оролцогчдод судалгааны зорилгыг танилцуулж, зөвшөөрөл авсан болно.

**Ашиг сонирхлын мэдүүлэг, талархал**

Судалгааны багт ашиг сонирхлын зөрчил байхгүй бөгөөд судалгаанд оролцогчид, судалгааны баг, болон дэмжлэг үзүүлсэн бүх хүмүүст талархал илэрхийлье.

**Ном зүй**

1. Мягмарсанж, Ц. (1983). Гэрийн даалгаврыг өгөх, шалгах, зохион байгуулах арга барил. Сурган хүмүүжүүлэгч, 5, 53-56.
2. Нямсүрэн, С. (2016). Хүүхдийн төлөвшил ба гэрийн даалгавар. Боловсрол судлал сэтгүүл, 9, 25-34.
3. Оюунчимэг, М. (2015). Биологийн хичээлийн гэрийн даалгавраар хүүхэд бүрийг хөгжүүлэх боломж (Магистрын зэрэг горилсон бүтээл). МУБИС, Улаанбаатар.
4. Сайнбат, Ч. (2013). Хүүхэд бүрийг хөгжүүлэх аргазүй- гэрийн даалгавар. Боловсрол судлал сэтгүүл, 10, 38-42.
5. Эрдэнэтуяа, О. (2014). Англи хэлний хичээлийн гэрийн даалгаварт анхаарах зарим асуудал (Магистрын зэрэг горилсон бүтээл). МУБИС, Улаанбаатар.

6. Cosio, M. N., & [Author]. (n.d.). Timing of homework completion vs. performance in general chemistry.
7. Guo L, Li J, Xu Z, Hu X, Liu C, Xing X, Li X, White H, Yang K. PROTOCOL: The relationship between homework time and academic performance among K-12 students: A systematic review. *Campbell Syst Rev.* 2021 Oct 26;17(4):e1199. doi: 10.1002/cl2.1199. Update in: *Campbell Syst Rev.* 2024 Sep 18;20(3):e1431. doi: 10.1002/cl2.1431. PMID: 36950338; PMCID: PMC8988773.
8. Hong, E., Milgram, R. M., & Rowell, L. L. (2004). Homework Motivation and Preference: A Learner-Centered Homework Approach. *Theory Into Practice*, 43(3), 197–204. [https://doi.org/10.1207/s15430421tip4303\\_5](https://doi.org/10.1207/s15430421tip4303_5)
9. Núñez, J. C., et al. (n.d.). Teachers' feedback on homework-related behaviors and academic achievement.
10. Núñez, J. C., Suárez, N., Rosário, P., Vallejo, G., Cerezo, R., & Valle, A. (2014). Teachers' Feedback on Homework, Homework-Related Behaviors, and Academic Achievement. *The Journal of Educational Research*, 108(3), 204–216. <https://doi.org/10.1080/00220671.2013.878298>
11. Ramdass, D., & Zimmerman, B. J. (2011). Developing self-regulation skills: The important role of homework. *Journal of Advanced Academics*, 22(2), 194-218.
12. Shih, S. S. (2016). Factors related to Taiwanese adolescents' academic procrastination, time management, and perfectionism. *The Journal of Educational Research*, 110(4), 415–424. <https://doi.org/10.1080/00220671.2015.1108278>
13. Xu, J. (2010). Predicting homework time management at the secondary school level: A multilevel analysis. *Learning and Individual Differences*, 20, 34-39.
14. Xu, J., Yuan, R., Xu, B., & Xu, M. (2014). Modeling students' time management in math homework. *Learning and Individual Differences*, 34, 33-42.
15. Yang, F., & Tu, M. (2019). Self-regulation of homework behaviour: relating grade, gender, and achievement to homework management. *Educational Psychology*, 40(4), 392–408. <https://doi.org/10.1080/01443410.2019.1674784>
16. Yang, F., & Tu, M. (2020). Self-regulation of homework behaviour: Relating grade, gender, and achievement to homework management. *Educational Psychology*, 40(4), 392-408.

## ABSTRACT

LANGUAGE PROFICIENCY AND OVERALL ACADEMIC  
ACHIEVEMENT FOR MEDICAL STUDENTS

*Munkhzaya.B1, Munkhtsetseg.G1  
Dep of Foreign language,  
school of Bio Medicine, MNUMS*

Homework plays a crucial role in enhancing academic performance, especially in language acquisition. For medical students, English proficiency is essential for accessing global knowledge and succeeding in their field. This study aims to examine the relationship between English homework completion timing and academic performance among medical students. A total of 48 students (70% female, 30% male) from different proficiency levels (beginner to upper-intermediate) participated. Data were gathered through an online survey, including sections on homework timing, average exam scores, and reasons for homework timing. Statistical analysis revealed a moderate negative correlation (-0.267) between homework timing and academic

performance, suggesting that students who delay homework completion tend to perform slightly lower. Results showed that most students prefer to complete homework the day before a class (54%), while others favor completing it 2-3 days later (40%), valuing retention over time. Students' reasons for their timing choices varied, with 42% citing other coursework as a barrier to earlier completion. The findings underscore the importance of time management and self-regulation in optimizing homework habits to improve English proficiency and academic outcomes. This study provides insights for educators to guide medical students in developing effective homework strategies that enhance both language learning and academic performance.